

Тогтвортой хөгжлийн боловсролын талаар баримталж буй бодлого.

Хүн төрөлхтөн 1950-60 оны үеэс байгаль орчны асуудалд онцгой анхаарах болсон юм. 1952 оны 12 сарын 5-нд Лондон хот хорт утаагаар бүрхэгдсэн, Японы Минамат хотын химийн үйлдвэр, Канадын Драйден хотын хуванцарын үйлдвэр зэрэг нь далайд мөнгөн устай хаягдал хаясан, хөвөнгийн талбайн усжуулалтын системийн буруугаас болж Аралын тэнгис 5 дахин багасаж цөлжилт үүссэн зэрэг технологийн алдаанаас үүдэн хүн төрөлхтний амьд явах цорын ганц зам бол байгаль орчноо хамгаалах явдал гэсэн үзэл санааг хүлээн зөвшөөрч эхэлсэн юм.

Нөгөө талаас, байгаль орчны асуудлыг дэлхийн түвшинд гаргаж тавихад 1969 онд Римийн клубт доктор Медоузийн тавьсан “Өсөлтийн хязгаар” илтгэл чухал үүрэг гүйцэтгэсэн юм. Эдийн засаг, нийгмийн системд дорвитой өөрчлөлт хийхгүй бол ойрын 100 жилд аж үйлдвэр бүх төрлийн сэргээгдэхгүй нөөцөө дуусгах бөгөөд үйлдвэрлэлийн хаягдлыг боловсруулж чадахгүйд хүрнэ гэж системийн сэтгэлгээний үүднээс дүгнэсэн байдаг. Энэ илтгэл нь НҮБ-ын 1972 оны Стокгольмын бага хурлын өмнө болсон нь цаг үеэ олсон чухал ач холбогдолтой болж улмаар НҮБ-ын Байгаль орчны хөтөлбөрийг шинээр байгуулахад хүргэсэн юм. Цаашлаад 1992 онд Рио-д болсон хөгжил ба байгаль орчны тухай бага хурал, 2002 онд Йоханнесбургд болсон тогтвортой хөгжлийн дээд хэмжээний уулзалтаас хойш улс орны хөгжил бол байгаль орчин, эдийн засаг, нийгмийн дэвшлийг тэнцвэртэйгээр нэгтгэж байж амжилтад хүрнэ гэдэг ойлголт бидний амьдралын философи болсон юм.

Өнгөрсөн зууны далаад оноос экологийн боловсролд илүү анхаарах болсон бөгөөд 1977 оны ЮНЕСКО-ЮНЕП-ийн хамтарсан экологийн боловсролын Тбилисийн тунхаглал, Риогийн тунхаглалаас гаргасан 21-р зууны тогтвортой хөгжлийн хөтөлбөр зэрэг нь тогтвортой хөгжлийг хангахад боловсрол чухал үүрэгтэй болохыг онцгойлон тэмдэглэсэн юм. Японы Засгийн газраас тогтвортой хөгжлийн асуудалд боловсрол ба хүний капиталын гүйцэтгэх үүргийг чухалчлан үзэж 2005-2014 онуудыг ТХБ-ын 10 жил болгон тэмдэглэхийг НҮБ-ын Ерөнхий Ассемблейд санал болгосноор ЮНЕСКО энэ 10 жилийн ажлыг толгойлох болсон нь миний ЮНЕСКО-д ажиллаж байсан үетэй давхацсан юм.

Тогтвортой хөгжлийн боловсролын үндэс суурийг бүр 18-р зуунд Жан Жак Руссо тавьсан гэж үздэг. Тэрээр хүүхдэд байгаль орчин, хүмүүс, юмс үзэгдэл гэсэн 3 хүчин зүйл нөлөөлж байдаг. Байгаль дэлхий хүүхдийн авьяас чадварыг хөгжүүлж байдаг бол түүнийг хүрээлж байгаа хүмүүс тэр чадвараа ашиглаж сурахад нь нөлөөлж байдаг. Харин юм үзэгдэлтэй танилцах явцдаа туршлага хуримтлуулж байдаг ажээ. Хүүхэд цэцгийг үнэртгэж, шувууны жиргээг чихээрээ сонсохгүйгээр байгалийн сайхныг мэдрэхгүй, газар зүйн хичээлийг ном карт ашиглаж биш орчинтойгоо танилцаж, ажиглах замаар илүү сурна гэж үзэж байжээ. Байгаль орчноо ажиглах замаар бие даан сэтгэн бодож сурдаг бол, янз бүрийн туршилт хийх замаар байгалийн ухааны хууль тогтолцоог судалж танин мэддэг, харин эх дэлхий, газар шороотой ажиллаж, цэцэг тарьж ургуулах зэргээр ажил хийлгэх замаар хүүхдэд байгалийн сайхныг мэдрүүлдэг гэх зэргээр экологийн боловсролын ач холбогдлыг 18-р зуунд номлож байсан байна. Толстой, Дьюи, Спенсер зэрэг олон сурган хүмүүжүүлэгчид түүний үзэл бодлыг цааш нь хөгжүүлсэн байна.

Тогтвортой хөгжлийн боловсрол бол насан туршийн боловсролын бүхий л хэлбэрүүдэд явагдаж байх ёстой.

Мэдээллээр цутгасан сургалтын арга нь гол төлөв тунхаг маягийн мэдлэг олгодог учраас сургалтын хөтөлбөр тогтвортой хөгжлийн үйл хэрэгт гар бие оролцох чадварыг олгож чадахгүй байна. Өөрөөр хэлбэл багшаас сурагчид өгч байгаа мэдлэгт бус оюутны эзэмшсэн мэдлэг ур чадварт илүүтэй анхаарах шаардлагатай болж байгааг анхааруулж байна. Үүнийг цогц чадамж эзэмшүүлэх арга гэж нэрлэж байна.

Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллагаас өөрчлөгдөж буй хөдөлмөрийн зах зээлд зохицох, тогтвортой хөгжлийн зорилтыг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлж бодитой хувь нэмэр оруулах, хүрээлэн байгаа орчиндоо ээлтэй шийдвэр гаргахад дуу хоолойгоо нэгтгэдэг, сошиал сүлжээ, мэдээллийн хэрэгслийг үр өгөөжтэй, хариуцлагатай хэрэглэдэг чадварыг **нийтлэг цогц чадамж** гэж тодорхойлоод энэ ойлголтыг эргэлтэд оруулжээ.

Нийтлэг цогц чадамжийг тодорхойлох талаар дэлхийн нэрт эрдэмтэд олон талаас нь судалж түүнд хамрах чадамжийг тодорхойлсон байна.

Системийн сэтгэлгээ бол нийгэм, эдийн засаг, байгаль орчны системүүдийг хамтад нь авч үзэж, тэдний хоорондын уялдаа холбоог илрүүлэхэд чухал ач холбогдолтой байна.

Орон зайн цогц чадамж бол орон нутгийн аливаа тулгамдсан асуудлыг шийдвэрлэхдээ дэлхийн хэмжээний үр дагаврыг харж тооцож чаддаг байхыг хэлж байна.

Цаг хугацааны цогц чадамж бол нэг талаас өнгөрсөн түүхээ сайн мэдэх, нөгөө талаас ирээдүйгээ харж чадахыг хэлж байна.

Мэдлэгийн салбар хоорондын цогц чадамж нь нарийн ээдрээтэй асуудлыг шийдэх чадварыг олгоно.

Соёлын цогц чадамж бол бусдыг хүндлэх, эрхээ хамгаалах, соёлын өвөө хайрлаж хамгаалах чадварыг хэлнэ.

Профессор Д.Бадарч